

"МОН-НАБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

"МОН-НАБ" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 03 -ны өдөр Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг б-р хороо Жуулчны гудамж -19, Хишиг төв 7 давхар 701 тоотод болов.

Хурал 14.00 цагаас эхлэж ТУЗ –н дарга Р.Зоригт даргалан явуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хувьцаа эзэмшигч:

- Т. Бадамжунай / 62400 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Р.Зоригт / 37497 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Ж.Энхрийлэн / 1 ширхэг хувьцаа эзэмшигч/ итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Жавхлан ЧР86090310

нар тус тус хүрэлцэн ирсэн

ТУЗ- н гишүүд :

- Ш.Оюун-Эрдэнэ
- Г.Төгөлдер
- Д.Болорцэцэг
- Л.Амарсайхан
- Р.Алтанцэцэг
- Л.Мөнхтуяа

нар хүрэлцэн ирж ирц 81,3 % байна гэж хурал зохион байгуулах комиссийн гишүүн Г.Төгөлдер танилцуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн болно. Үүнд:

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны , санхүүгийн байдалд ТУЗ-н ёгсөн дүгнэлт ;
- ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлах;
- Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг хэлэлцэж батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хуралд "Компанийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд ТУЗ-ийн хийсэн дүгнэлт" - ийг ТУЗ-ийн дарга Р.Зоригт танилцуулж, дараах нэмэлт тайлбарыг хийв.

2025 оны ХЭХуралд ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Хувьцаа эзэмшигчид 2024 онд ээлжит хурлаа амжилттай хийсэн.

Та бүхэн компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцсан байх.

Компанийн енеегийн байдал өдөр тутмын асуудлыг шийдвэрлэж байгаа ч бүх зардлууд нэмэгдсээр байна. Компанийн гадна дулааны ажлыг хийж байгаа "Хажуу ус" ХХК -н хүмүүс манай байгууллагатай тохирсон ажлаа хагас дутуу хийсэн. ялтсан бойлуур тавих ,дотор дулааны шугамын засварын ажил дулааны үзелийн барилга засварыг хийгээгүй . Жил бүр төлдөг урсгал зардлуудыг эзний өөрийн хөрөнгөөр төлж барагдуулж байгаа. Өр төлбөрөө бага багаар төлж барагдуулж л байна. Санхүүгийн байдал хүнд .СЗХороо, Хөрөнгийн Биржээс ирүүлсэн албан тоот, даалгаваруудад хариу ёгех талаар их анхаарч ажилласан. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ,АТҮТ ,Хажуу ус ХХК -н ажил хариуцсан хүмүүстэй ахиж уулзаж гэрээгээ дүгнэх хэрэгтэй байна. Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан санал шүүмжлэл дараах байдлаар өрнөв.

Үүнд:

Ш.Оюун-Эрдэнэ: Шинэ хувьцаа эзэмшигчийн бие төлөөлөгч хуралд ирсэнд баярллаа. ХЭХурлын зар хүргэх журмын дагуу явагддаг .Бид олон нийтийн сонин хэвлэл ,брокер пүүс ,утсаар хүртэл яриад байхад хуралд ирэх нь цөөхөн байна.Хувьцаа эзэмшигчид хурлын зар, бичиг баримт хуралд хэлэлцэх асуудал,байгууллагын өнөөгийн байдлын талаар мэдээллийг олон сувгаар авах боломжтой.ТУЗ -н гишүүд үүргийнхээ дагуу ажиллаж байгаач цалин урамшуулал байхгүй байна. Хэдий санхүүгийн боломж муу байна гээд цалин өгч чадахгүй байгаад байхуу .Цаашид орон тоо цалин урамшуулалын талаар бодож шийдвэрлэх юм их байна.

Р.Алтанцэцэг: Санхүүгийн тайлан аудит хийлгэх ажил гэрээний дагуу "Ай Жэй Эй ЭЙЧ-АУДИТ"ХХК –аар аудитын гэрээ хийж дүгнэлт гаргуулсан төлбөр менгэ нэмэгдсэн хойшид хамтран ажиллах болно.

Ж.Энхрийлэн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Жаевхлан: Сайн байцаана уу би хүүхдийнхээ өмнөөс хуралд оролцож байгаа юм.Танай байгууллага ямар үйл ажиллагаа явуулдаг юм бэ.Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт,үйл ажиллагааны тайлантай танилцаа.

Р.Зоригт: Энэ компани Нийгэм ахуйн барилга эрхэлдэг нэг ёсондоо цэвэр бохир ус дулааны шугамын ажил хийдэг байгууллага .

Д.Болорцэцэг: Үндсэн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл энээ тэрээ юм шаарддаг юм Ажиллах боловсон хүчин хэрэгтэй, сайн ажилчид хэрэгтэй . Зээл авах талаар хөөцөлдсөн юм байна уу. Хувьцаа эзэмшигчид хуралдаа муу оролцож байна.
Ж.Энхрийлэн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Жаевхлан: Хувьцаат компани маань хувьцаа гаргах уу.Хувьцаагаа арилжих хөрөнгө босгох уу.

Р.Зоригт: Ер нь бол бид Компанийн үйл ажиллагааг бол барилгын чиглэлийг нь хадгалаад явна гэсэн бодолтой байгаа. Хувьцаат компанийн хувьд өөр чиглэлийн ажил хийнэ гэдэг хэцүү. Хөрөнгө оруулалтын ажлаа ийшээ чиглүүлнэ гэсэн бодолтой. Одоогийн инженер техникийн ажилтнууд цалин өндөртэйгээр бусад газруудад ажиллаж байна.

Ш.Оюун-Эрдэнэ Компанийн ТУЗ н гишүүд цаашид хариуцсан чиглэлээр санал санаачлага гаран ажилмаар байна. Компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдах хэрэгтэй байна.Энийг СЗХорооноос шаардаад байгаа.

Маш олон заавар ,журам,хетелбөр батласан өдөр тутмын ажилдаа мөрден ажиллаж байна.Цалин шийдэж өгөх шаардлагатай байна .

Р.Зоригт: Цалин шийдэж өгөх гэхээр санхүүгийн хувьд боломжгүй байна. Энэ жил ч энэ байдал хэвээр байх болоплой тиймээс тэсэж байхыг хүсье. Төслийн ажил хөөцөлдөж байна.Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байгаа.

Р.Алтанцэцэг: Зээлийн шаардлагад манай байгууллага нийцэхгүй байгаа.ТУЗ-н хувьд гишүүдээ ажлуулмаар санал бодлыг сонсож тусламж дэмжлэг авмаар байна . Р.Зоригт ТУЗ-н даргын хувьд ч хувьцаа эзэмшигчийн хувьд ч идэвхи гарган янз бүрийн юмны өмнө л байх юм .

Л.Мөнхтуяа: Адил чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага хувь хүмүүстэй хамтарч ажил хийвэл болохгүй юу. Одоо хүн бүрийн хүчин зүтгэл хэрэгтэй гэж бодож байна.

Л.Амарсайхан: Таны санал бас бодож үзмээр юм байна. Цаашид ямар ажил төлөвлөж байна вэ? Инженер, техникийн ажилтнууд байна уу?

Хувьцаа эзэмшигчид нь дандаа энэ байгууллагад ажиллаж байсан хүмүүс биздээ.

Р.Алтанцэцэг: Бид энэ компанийн ажлыг өөднө татаж цаашид юу хийж яаж ажиллах талаар сайн ярилцмаар байна. ТУЗ-н хурал хийхээр ирчээл бусад үед оролцоо муу байна.

Т.Бадамжуунай: Тайллан болон Хурлын хэлэлцэж байгаа асуудалтай санал нэг байна. Хурлаас гарах шийдвэрийг дэмжинээ.

Д.Болорцэцэг: Хөрөнгө оруулалт татах төсөл хэрэгжүүлэх хэрэгтэй юм шиг санагдах юм. ТУЗ-н гишүүд идэвхи санаачлага муутай байна.

Хувьцаа эзэмшигчид шуумжлээд байхаас биш бид ямар үүрэгтэй байх вэ явавл зин байгууллагыг сайн болгох тухай олигтой санал хэлдэгүй. Шинээр сэтгэх хэрэгтэй гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн цаащдын зорилтыг хэлэлцэв. Компанийн цаащдын зорилтыг хэлэлцэн батлахтай холбогдуулан Р.Зоригт өөрийн саналаа хэлэв:

- 2025 онд Санхүүгийн байдлаа сайжруулах өр төлбөрийн асуудлаа дуусгах;
- ТУЗ н дэд хороод компанийн засаглалын дүрэм журамын дагуу ажиллах;
- Хөрөнгө оруулалт татах ажлыг судлаж шийдвэрлэх;

Компанийн тухай хуулийн 77р зүйлийн 77.2. Компанийн дурмийн 10.6 -д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн зэлжит хурлаар ТУЗ-н гишүүдийн бүрэн эрхийн хугацааг дараагийн зэлжит хурал хуртэл сунгаж дэд хороодууд одоо байгаа бүрэлдхүүнээрээ ажиллахаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал нэгтэй батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн зэлжит хурал тогтоол гаргахаар тогтоож, тогтоолын төсөл бурийг хэлэлцэж, тэдгээрийг санал нэгтгэйгээр батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн зэлжит хурал 16.00 цагт дуусав.

ХУРЛЫН ДАРГА
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Р.Зоригт

Д.Болорцэцэг

Р.Зоригт

Д.Болорцэцэг